



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/681

Булган сум

**Сонгуулийн нэмэлт санал хураалт явуулахтай
холбогдуулан архи, согтууруулах ундаа худалдах,
түүгээр үйлчлэхийг хориглох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймаг нийслэл сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн дагуу Булган аймгийн Гурванбулаг, Сайхан, Дашинчилэн, Баян-Агт сумын зарим хэсгийн хороонд 2024 оны 10 дугаар сарын 13-ны "Ням" гаригт нэмэлт санал хураалт явуулах болсон тул нэмэлт санал авах өдөр, нэмэлт санал авах өдрийн өмнөх болон дараагийн өдөр буюу 2024 оны 10 дугаар сарын 12, 13, 14 -ний өдрүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн дэд хурандаа Г.Ганбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6321010952